

2022 оны 10 сарын 14

ARD СЕКЮРИТИЗ
ҮЦК

ГАДААД ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ



ОНЦЛОХ МЭДЭЭ

- Баавгайн зах зээлийн талаар товч мэдээлэл
- Өнгөрсөн 7 хоногт инфляцын түвшин өссөн талаар тааруухан мэдээ гарсан ч хөрөнгийн зах зээл өсөлтөө хадгалж чадсан нь анхаарал татахуйц байлаа

2022.10.17-ны pre-trading session байдлаар

АНУ	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	1 жил
US30	29,822.00	0.64%	2.12%	-3.86%	-15.34%
US500	3,608.40	0.62%	-1.42%	-11.83%	-17.05%
NASDAQ	10,987.62	0.71%	-1.45%	-9.91%	-29.62%
Европ	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	1 жил
GB100	6,859.00	0.12%	-1.89%	-5.81%	-5.19%
DE40	12,438.00	0.67%	1.34%	-4.00%	-20.21%
FR40	5,932.00	0.90%	1.11%	-3.67%	-11.83%
IT40	20,931.00	0.70%	0.14%	-6.42%	-20.98%
ES35	7,383.00	0.46%	-0.73%	-8.69%	-17.94%
Ази	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	1 жил
JP225	26,751.00	-1.40%	1.27%	-3.40%	-7.87%
SHANGHAI	3,064.00	-0.25%	3.04%	-1.64%	-14.12%
CSI 300	3,819.00	-0.60%	2.65%	-2.76%	-21.65%
SHANGHAI 50	2,571.00	-0.51%	1.04%	-4.03%	-20.38%
CH50	12,693.80	-0.99%	0.84%	-3.29%	-19.06%
SENSEX	57,793.00	-0.22%	-0.34%	-2.28%	-6.43%
Эрчим хүч	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	1 жил
Газрын тос (Crude)	86.47	1.01%	-5.09%	1.33%	7.12%
Газрын тос (Brent)	92.23	0.64%	-4.10%	1.74%	9.38%
Байгалийн хий	6.29	-2.50%	-2.17%	-19.33%	26.19%
Шатахуун	2.64	0.42%	0.80%	9.47%	6.33%
Нүүрс	392.50	-1.13%	1.95%	-11.90%	63.54%
Түүхий эд	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	1 жил
Алт	1,651.37	0.58%	-0.95%	-1.42%	-6.38%
Мөнгө	18.46	1.08%	-5.95%	-5.75%	-20.22%
Зэс	3.43	-0.60%	-0.39%	-2.79%	-27.28%
Бонд /10 жил/	Өгөөж	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	1 жил
АНУ	3.9936	0.0124	0.05%	0.51%	2.41%
Англи	4.3270	0.1330	0.09%	1.16%	3.22%
Швейцар	1.3880	0.1500	0.00%	0.31%	1.49%
Испани	3.5190	0.0660	0.12%	0.61%	3.05%
Герман	2.3610	0.0610	0.16%	0.62%	2.53%

Баавгайн зах зээлийн талаар товч мэдээлэл

Өнгөрсөн 7 хоногт инфляцын түвшин өссөн талаар тааруухан мэдээ гарсан ч хөрөнгийн зах зээл өсөлтөө хадгалж чадсан нь анхаарал татахуйц байлаа. 9 сарын хэрэглээний үнийн индекс өссөн гэсэн боловч өнгөрсөн Пүрэв гарагт хөрөнгийн зах зээл 2022 оны доод түвшнээ хадгалж үлдсэн. Инфляцтай холбоотой ханшийн хэлбэлзэл үргэлжилж магадгүй ч зах зээл дээр ажиглагдаж байгаа ханшийн хөдөлгөөнөөс харахад ихэнх учирч болох уналт болоод өнгөрснийг илтгэж байна.

Баавгайн зах зээлийг туулахад бэрхшээлтэй байдаг. Урт хугацаат хөрөнгө оруулагчдыг богино хугацааны арилжаа эрхлэхэд хүргэдэг. Шинжээчид одоогоор “U” хэлбэртэй сэргэлтийн суурь тавигдаж эхэлсэн гэж үзэж байгаа тул зөв стратегитайгаар хөрөнгө оруулалтаа удирдахыг зөвлөж байна. Доорх хүснэгтээс харахад, бид энэ удаагийн баавгайн зах зээлийн төгсгөл хэсэгт явж байгааг илүү тодорхой харуулжээ.

Төгсгөл рүүгээ ойртоход томоохон уналтын дараагаар хүчтэй өсөлтүүд үргэлжилдэг

Баавгайн зах зээл	1% хүртэл унасан өдрүүдийн тоо	=/>2% унасан өдрүүдийн тоо	1% хүртэл өссөн өдрүүдийн тоо	=/>2% өссөн өдрүүдийн тоо
1962	15	5	2	3
1970	11	3	4	1
1974	18	10	5	5
1982	9	0	6	0
1987	10	11	8	8
2002	11	18	9	9
2009	9	16	5	8
2022	11	5	10	6

- Дээрхээс харахад уналт үргэлжилсэн өдөр ихсэх тусам өсөлт үзүүлсэн өдөр дагаад ихэссэнийг харуулж байна.
- Төв банкны бодлогын хүүгийн нэмэлт өсөлтүүд, уналттай эдийн засаг зэрэг мэдээнээс хамаарч хөрөнгийн зах зээлд хүндрэлүүд нэмж учирч магадгүй. Гэвч дээрх хүснэгтээс харахад, уналтын дараахан өсөлт үзүүлдэг нь тодорхой байна. Өнгөрсөн 10 хоногт л гэхэд S&P 500 индекс 2.5%-иар өссөн.

Хөрөнгийн зах зээл дээр ёроол ханш тогтсоны дараах 1-2 жилийн өгөөж

Баавгайн зах зээл	Нийт уналт	1 жилийн дараах өгөөж	2 жилийн дараах өгөөж
1961-1962	-28%	37%	67%
1969-1970	-36%	49%	71%
1973-1974	-48%	44%	82%
1980-1982	-27%	66%	77%
1987	-34%	26%	69%
2000-2002	-49%	36%	50%
2007-2009	-57%	72%	103%
Дундаж	-40%	47%	74%
2022	-25%	?	?

Өнгөрсөн 7 удаагийн баавгайн зах зээлийн уналт дунджаар 40%-тай байв. Энэ жилийн уналт дунджаас хамаагүй бага байгаа ба 40%-ийн түвшинд хүрэхгүй гэж харж байна. 1970-аад оны уналт газрын тосны ханш болон томоохон эдийн засгийн уналттай холбоотой байсан. 2000 оны эхээр технологийн компаниудын зах зээлийн үнэлгээний хөөс хагарахаас гадна 9 сарын 11-ний террор халдлага тохиосон.

- 2007-2009 оны уналт үл хөдлөх хөрөнгийн хөөс хагарч, санхүүгийн хямрал болсон. Хэрвээ дээрх жишээнүүдийг тооцохгүй бол баавгайн зах зээлийн дундаж уналт 30% байгаа нь одоогийн 25%-иас тийм ч холгүй байна.
- Уналттай нүүр тулах амаргүй ч энэ нь хөрөнгө оруулалтын салшгүй нэг хэсэг билээ. Хамгийн гол нь зорилгодоо хүрэхийн тулд, туулж буй замаасаа хөндийрөхгүй байх дээр анхаарах хэрэгтэй. Ингэснээр та сэргэлтийг урьдчилан таамаглахад илүү амар болсноор 1 жилийн дотор дунджаар 50% хүртэлх өгөөжийг хүртэх боломжтой болно.
- Гэвч шинжээчид одоогоор сэргэлт болох нөхцөл хараахан бүрдээгүй гэж үзэж байна. Төв банк бодлогын хүүний өсөлтөө сааруулснаар хөрөнгийн зах зээлийн сэргэлт эхэлнэ гэж харж байна.

Баавгайн зах зээл хэд насалдаг вэ?



Дээрх зураг нь 2022 оны S&P 500 индексийн хөдөлгөөнийг өмнөх баавгайн зах зээлүүдийн дундаж хөдөлгөөнтэй харьцуулан харуулав.


Эдийн засгийн өсөлт тааруухан байх боловч хөрөнгийн зах зээл бага зэргийн хямралыг аль хэдий нь ханшиндаа тусгасан



S&P 500 индексийн 2022 оны ханшийн хөдөлгөөнийг 1982 оныхтой харьцуулав.

- Дээрх графикуудаас харахад, өнгөрсөн баавгайн зах зээлүүдийн уналт 20%-иас цааш саарч, тогтвортой өсөлт эхэлсэн байна. Энэ үзэгдэл энэ удаагийн баавгайн зах зээлд давтагдахыг үгүйсгэхгүй ба төв банкны цаашдын байр сууриас ихээхэн шалтгаална.
- Дээрх 1980-аад оны баавгайн зах зээл нь өндөр инфляц болон бодлогын хүүгийн түвшинтэй байснаараа энэ удаагийнхтай их төстэй.

Баавгайн зах зээл дунджаар хэдэн сар үргэлжилдэг вэ?



Дээрх зургаас харахад баавгайн зах зээл дунджаар 13 сар үргэлжилсэн байна.

- 2022 оны буюу одоогийн баавгайн зах зээл 10 сар үргэлжилсэн нь ердөө хэдхэн сар цаана нь үлдсэнийг харуулж байна. Энэ удаагийн эдийн засгийн хямрал харьцангуй зөөлөн байх магадлалтай байгаа тул 1973, 2008 оны гүн хямралууд шиг биш байх болов уу.

Хямралын дараагаар аль хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн хамгийн их өгөөжтэй байдаг вэ?



Эх сурвалж: edwardjones.com

- Дээрх зургаас харахад бага зах зээлийн үнэлгээтэй компаниудын хувьцааны ханш хамгийн их өссөнийг харуулж байна.
- Энэ удаагийн баавгайн зах зээлээр эдийн засгийн мөчлөг болон бодлогын хүүнд мэдрэмтгий компаниудын хувьцааны ханш их уналттай байсан. Өнгөрсөн явдлаас харахад эдгээрх салбарууд баавгайн зах зээл дуусаж, сэргэлт эхлэхэд хамгийн хүчтэй өссөн байна.
- Энэ удаагийн баавгайн зах зээлд ажиглагдсан хамгийн хачирхалтай зүйл нь хувьцаа болон бондын өгөөж хоёулаа адилхан уналаа. Өнгөрсөн явдалд уг нь бонд хувьцааны уналтаас сэргийлэхэд ашиглагддаг байсан. Гэвч энэ удаа бодлогын хүү өссөн тул бондын ханш мөн унасан.